



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/435

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 86 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААХААГ/20240203042 дугаар бүхий Дарив сумын Харгана түрүүний услалтын системийн тариалангийн 172 га талбайн зураг төсөл хийх ажлыг "Цэгц зураглал прожект" ХХК -тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Дарив сумын Засаг дарга (М.Мэндбаяр)-д олгосугай.

2. Ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Дарив сумын Засаг дарга (М.Мэндбаяр)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

